



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2026 оны 01 сарын 14 өдөр

Дугаар A/14

Улаанбаатар хот

Гишүүнчлэлийн жилийн хөлс хөнгөлөх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, “Гишүүнчлэлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтууд болон 2025 оны нийт арилжааны тайланг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2025 оны үнэт цаасны арилжааны үнийн дүнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх гүйлгээг дангаар хийсэн гишүүн үнэт цаасны компаниудыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалын хавсралтад дурдсан үнэт цаасны компаниудын 2026 оны үйлчилгээний хөлснөөс 10 хувиар хөнгөлсүгэй.
3. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2026 оны гишүүнчлэлийн жилийн хөлсийг хөнгөлсөн дүнгээр тооцож нэхэмжлэхийг Ерөнхий нягтлан бодогч (Д.Нарангэрэл)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт тус тус даалгасугай.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МӨНХБАТ

1526030026

Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гүйцэтгэх захирлын
2026 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн
А/У дугаар тушаалын Хавсралт



Д/д	Код	Гишүүн ҮЦК-ийн нэрс	Арилжааны үнийн дүн	Эзлэх хувь
1	GLMT	"ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК	383,016,368,216.10	22.96%
2	TDB	"ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИЗ ҮЦК" ХХК	313,214,867,882.91	18.78%
3	INVC	"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК	274,103,570,587.47	16.43%
4	BDSC	"БИ ДИ СЕК ҮЦК" ХК	134,200,277,551.65	8.05%
5	MIBG	"МАНДАЛ КАПИТАЛ МАРКЕТС ҮЦК" ХХК	97,838,338,201.17	5.87%
6	TNGR	"ТЭНГЭР КАПИТАЛ ҮЦК" ХХК	95,721,018,224.09	5.74%